Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 589,703.5 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр нэмэгдэж, бараа материал, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,162.5	6,227.4	2,064.9
Авлага	348,983.5	612,266.6	263,283.1
Урьдчилгаа	-	55,111.0	55,111.0
Бараа материал	1,052,465.9	11,811.6	(1,040,654.3)
Үндсэн хөрөнгө	16,979,436.0	17,109,927.9	130,491.9
Нийт хөрөнгө	18,385,047.9	17,795,344.4	(589,703.5)
Өр төлбөр	35,699.3	53,945.8	18,246.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	18,349,348.6	17,741,398.6	(607,950.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	18,385,047.9	17,795,344.4	(589,703.5)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 6,227.4 мянган төгрөг болж 2,064.9 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоол Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчид оюутны хөгжлийн зээл олгох, эргэн төлүүлэх журмын 4.1.3-д зээлийн 5 хувьтай тэнцэх хэмжээгээр “Зээлийн эрсдэлийн сан” бүрдүүлж байршуулснаар, худалдаа хөгжлийн банкинд байрших цалингийн түр дансанд үлдэгдэл үүссэнээс шалтгаалжээ. Энэ нь Худалдаа хөгжлийн банкинд ковидын шинж тэмдэг илрээд төв болон харилцдаг салбарууд ажиллахгүй, залгаахаар утсаа авахгүй,

гүйлгээ хийсэн файл мэдээллээ тухай бүртээ явуулсан боловч, гүйлгээ гаргаагүйтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 612,266.6 мянган төгрөг болж 263,283.1 мянган төгрөгөөр өссөн нь сургалтын төлбөрийн авлагын өсөлтөөс голлон шалтгаалсан. Авлага дансны үлдэгдэлд тайлант жил үүссэн Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулаагүй үлдэгдлийн төвлөрүүлэн шилжүүлсэн буцаан тооцох авлага 538,093.2 мянга, оюутны сургалтын авлага 72,667.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын байгууллагаас 1,189.8 мянган төгрөг, Ажилчдаас авах авлага 315.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 11,811.6 мянган төгрөг болж 1,040,654.3 мянган төгрөгөөр буурсан нь аудитын явцад бараа материалын дансанд бүртгэлтэй байсан 1,044,062.6 мянган төгрөгийн хангамжийн материал болон бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг данс бүртгэлээс хасч залруулснаас шалтгаалсан. Бараа материалын данс нь төсвийн хөрөнгөөр 137,608.1 мянга, хандив тусламжаар 68,728.4 мянган төгрөгөөр өсөж, тайлант оны зарцуулалт 203,354.0 мянга, бараа материалын дансанд бүртгэлтэй байсан 1,044,062.6 мянган төгрөгийн ашиглалтад байгаа бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн залруулга хийж хассанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 17,109,927.9 мянган төгрөг болж 130,491.9 мянган төгрөгөөр өссөн нь хичээл үйлдвэрлэл, сургуулийн орчныг сайжруулахаар худалдан авсан хөрөнгө өссөнөөс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 86,955.8 мянга, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс өгсөн хандиваар 725,891.2 мянга, 4,206.0 мянган төгрөгийн зээлээр авсан хөрөнгөөр нэмэгдэж, тайлант жил тооцсон 686,561.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурахад нөлөөлсөн байна.

Биет бус хөрөнгө урсгал төсвийн худалдан авалтаар 14,459.5 мянган төгрөг, хөрөнгө Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс өгсөн хандиваар 159,339.6 мянган төгрөгийн хөрөнгө авснаар нэмэгдэж, тайлант жил 1,009.8 мянган төгрөгийн байгуулсан хорогдлоор буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 53,945.8 мянган төгрөг болж 18,246.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилийн сургалтын төлбөрийг 10 хувь, байрны төлбөрийг нэг улирлаар чөлөөлснөөр оюутны сургалтын төлбөр урьдчилж орсон орлого нь өссөнөөс шалтгаалсан ба 48,957.5 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлого нийт өр төлбөрийн 90.9 хувийг нь эзэлж байна.

Бусад 4,988.3 мянган төгрөгийн өр төлбөр нь номын үнэ 4,206.0 мянган төгрөг, цалингийн тооцоолол буруу хийгдсэнээс 315.9 мянган төгрөг, 466.4 мянган төгрөгийн ажилтанд өгөх нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 17,741,398.6 мянган төгрөг болж 607,950.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант жил үр дүн алдагдалтай байснаас шалтгаалжээ. Энэ нь авлагын үлдэгдлийн залруулгаар 2,422.6 мянган төгрөгөөр өмнөх үр дүн нэмэгдэж, тайлант хугацааны үр дүнгээр 610,372.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласнаас шалтгаалжээ.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 433,983.7 мянган төгрөгөөр буюу 12.2 хувиар өссөн байна.

Төсвийн тусламж санхүүжилтийн орлого өмнөх оны үзүүлэлтээс 433,983.7 мянган төгрөгийн орлого нэмэгдсэн байна. Энэ нь улсын төвлөрсөн төсвөөс авсан санхүүжилтийн орлого 33,707.0 мянган төгрөгөөр буурч, суралцагчдын тоог нэмснээр өөрийн орлого 192,378.9 мянга, тендер, түрээсийн орлого 1,245.3 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 171,079.8 мянга, Засгийн газраас олгосон нийгмийн даатгалын

хөнгөлөлтийн орлого 102,986.7 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нийт орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 539,134.5 мянган төгрөгөөр буюу 17.4 хувиар өссөн байна. Үүнд байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 8,117.8 мянга, хангамж, бараа материалын зардал 43,121.5 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 27,944.5 мянга, хичээл сургалт, үйлдвэрлэлийн болон бараа үйлчилгээний бусад зардал 211,569.7 мянга, урсгал шилжүүлэг 331,628.2 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 12,098.7 мянган төгрөгөөр өсөж, цалингийн зардал 15,764.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамж 77,911.2 мянга, томилолтын зардал 1670.0 мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 2,422.6 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь тооцоо нийлсэн актаар урьд онуудад байсан авлагын үлдэгдлийг залруулснаас шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,353,036.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,353,036.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 2020 оны 01 дүгээр сарын 14-нд 2,574,164.5 мянган төгрөгөөр, 2020 оны 12 дугаар сарын 25-нд төсвийг тодотгож 2,395,913.8 мянган төгрөг болгож эхний төсвийн төслөөс 778,871.5 мянга, тодотголоор дахин 178,871.5 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

Тус байгууллага нь багш ажилчдыг тоог нэмэх, мэдээлэл сурталчилгаа их хийж оюутны тоог нэмэгдүүлэх санал оруулсан боловч төсвийг нэмээгүйгээс 2020 оны төсвөөс цалин, нийгмийн даатгалын зардал 404,744.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 25,943.7 мянга, хангамж, бараа материалын зардлыг 15,612.9 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 49,842.0 мянга, томилолт, зочны зардлыг 7,442.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 137,424.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 137,862.2 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан нь материаллаг дүнтэй байна.

Мөн дахин тодотголоор Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хичээл сургууль ороогүйгээс үйлдвэрлэлийн дадлага, томилолт, шатахуун, тогтмол зардлууд 178,871.5 мянган төгрөгөөр хэмнэгдсэнийг улсын төсөвт төвлөрүүлж төсвийг бууруулсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх дээд боловсрол хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,395,913.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,782,152.2 мянган төгрөгийг улсын төсвөөс 613,761.6 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,771,862.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 847,724.2 мянга, нийт 2,619,586.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,198,798.6 мянган төгрөгийг зарцуулж 418,723.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, 2,064.8 мянган төгрөгөөр мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нэмэгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,198,798.6 мянган төгрөг буюу 91.8 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 112,366.5 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 10,512.3 мянга, хангамж, бараа материалын зардлыг 11,923.5 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 16,462.5.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 28,819.2 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 16,815.2 мянга, урсгал шилжүүлгийг 216.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн дээд боловсрол хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 196,899.2 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал арга хэмжээ 216.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Код	Нэр				
71803	Монгол германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн дээд боловсрол	2,395,913.8	2,198,798.6	(197,115.2)	91.8
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,293,886.8	2,113,899.0	(179,987.6)	92.2
80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	17,289.7	6,999.1	(10,290.6)	40.5
80219	Харуул хамгаалалтын зардал	32,400.0	32,400	-	100.0
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	51,517.5	44,896.5	(6,621.0)	87.1
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	820.2	640.0	(216.0)	73.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар 2020 онд 613,761.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 847,724.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, үндсэн үйл ажиллагааны орлогыг 38.1 хувиар буюу 232,717.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	613,761.6	846,478.9	(232,717.3)	37.9
Туслах үйл ажиллагааны орлого		1,245.3	(1,245.3)	100
Нийт дүн	613,761.6	847,724.2	(233,962.6)	38.1

Энэ нь сурталчилгаа сайн хийгдэж оюутны тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор үндсэн үйл ажиллагааны орлого 232,717.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд гадаад төсөл хөтөлбөрөөс 366,753.9 мянга, татаас санхүүжилтийн авлагаас 268,153.4 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 19,408.9 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 94,625.2 мянга, нийт 748,941.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Энэ санхүүжилтээр цалин нийгмийн даатгалын зардалд 56,791.7 мянга, хангамж, бараа материалын зардалд 110,472.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 40,983.0 мянга, нийт 208,247.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 540,694.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 156 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, хугацаа хоцроосон 19 мэдээлэл байршуулж, хугацаа болоогүй 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны хуулийн дагуу байршуулах мэдээллээс хугацаа хоцроосон 19 мэдээлэл нь тушаал шийдвэр 7, батлагдсан төсөв, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, тендерийн ерөнхий мэдээлэл, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан тус бүр 1, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 2, төсвийн хэтрэлт хэмнэлт 3 хоцорсон байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 69,292.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 116,489.9 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	3,000.0	1	3,000.0	-	-	100.0
Албан шаардлага	1	69,292.8	1	69,292.8	-	-	100.0
Зөвлөмж	5	116,489.9	5	116,489.9	-	-	100.0
Нийт дүн	7	188,782.7	7	188,782.7	-	-	100.0

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,059,628.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,045,763.0 мянган төгрөгийн алдааг залруулж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 13,865.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаанд гурван залруулга хийж санхүүгийн тайланд тусгаж баталгаажуулав. Үүнд:

1. Бараа материал: Бараа материалын дансанд гүйцэтгэлийн үе шатанд горим сорил хэрэгжүүлэхэд бараа материалын дансанд 1,044,062.6 мянган төгрөгийн ашиглалтад байгаа бараа материал бүртгэлтэй байна.
2. Цалингийн зардал: Цалингийн зардлыг хамаарагдах хууль тогтоомжийн дагуу хөөн шалган үзэхэд төслийн болон цагийн багш нарын цалингаас 315.9 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу олгох хөнгөлөлтийг давхар эдлүүлсэн байна.
3. Мөнгөн хөрөнгө: Мөнгөн хөрөнгийн дансдын үлдэгдлүүдэд явуулсан тулган баталгаажуулах захидлын хариугаар Худалдаа хөгжлийн банкин дахь цалингийн түр данс 1,384.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд нэг албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Шилэн дансны хуулийн дагуу шалгахад нийт 156 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 135, хугацаа хоцроосон 19 мэдээлэл нь тушаал шийдвэр 7, батлагдсан төсөв, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, тендерийн ерөнхий мэдээлэл, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан тус бүр 1, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 2, төсвийн хэтрэлт хэмнэлт 3 хоцорсон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө,... жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.5-д "... аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор", 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.2.4-д "хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ"-д 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 6.4.1-д "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт", УСНББОУС-ын 1-ийн 27 зүйл: "... үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг..." заалтуудтай нийцэхгүй, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 13,865.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн захирлыг тус сургуулийн удирдах зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 34 тоот тогтоолоор үүрэгт ажлаас чөлөөлснийг БШУС-ын 2019 оны 08 дугаар сарын 30-ний өдрийн Б/38 тоот тушаалаар батламжилсан боловч үндэслэлгүй гэж үзэн Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасныг хэрхэн шийдвэрлэснийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Зардлын анхан шатны и-баримтын нийт 688 гүйлгээ, 672,847.4 мянган төгрөгийн, 170-аад аж ахуйн нэгж, хувь хүмүүсээс авсан худалдан авалтыг тулган шалгахад урьд оны худалдан авалтын 36,334.4 мянган төгрөг, 2021 онд бүртгэгдсэн 12,342.5 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй байна.

Энэ нь үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно", 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.2 Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээ бүртгэж, тайлагнасан байх.

1.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт хийхдээ хууль тогтоомж, журмын дагуу татварын цахим системд и-баримтыг харилцагч байгууллагуудаар бүрдлийг хангуулж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

И-баримтын шивэлтийг сар бүр шалгаж ажиллана.

2.2 Балансын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Грийн Химистри ХХК-ийн өмнөх онуудад үүссэн авлагын үлдэгдлийг аудитаар илрүүлж, залруулж бүртгэснээс авлага оны эцэст 1,207.1 мянга, цалингийн тооцооллын алдаанаас илүү олгосон хөнгөлөлтийг аудитын явцад илрүүлснээр үүссэн Ажилчдаас суутган авах авлага 315.9 мянга, ХХОАТ-ын өглөг 315.9 мянган төгрөгөөр тус тус үлдэгдэлтэй тайлагнагдсан.

Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх.

2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2021			САГ-2021/47/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол Германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургууль		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллагатай тооцоо нийлж тулган баталгаажуулснаар Грийн хмистрий ХХК-ийн өмнөх онуудад үүссэн авлагын үлдэгдэлийг аудитаар илрүүлж, залруулж бүртгэснээс авлага оны эцэст 1,207.1 мянга, цалингийн тооцооллын алдаанаас илүү олгосон хөнгөлөлтийг аудитын явцад илрүүлснээр үүссэн Ажилчдаас суутган авах авлага 315.9 мянга, ХХОАТ-ын өглөг 315.9 мянган төгрөгөөр тус тус үлдэгдэлтэй тайлагнагдсан.	1,523.0	Зөвлөмж өгөх	Тооцооны нягтлан бодогч	Боря Мягмархүү
2	Шилэн дансны хуулийн дагуу шалгахад нийт 156 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 135, хугацаа хоцроосон 19, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Шилэн дансны хуулийн дагуу байршуулах мэдээллээс хугацаа хоцроосон 19 мэдээлэл нь тушаал шийдвэр 7, батлагдсан төсөв, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, тендерийн ерөнхий мэдээлэл, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан тус бүр 1, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 2, төсвийн хэтрэлт хэмнэлт 3 хоцорсон байна.	0	Албан шаардлага	Тооцооны нягтлан бодогч	Боря Мягмархүү
3	Зардлын ажил гүйлгээг анхан шатны баримт руу шалгахад баримтын бүрдэл дутуу гүйлгээ гараагүй байна. Мөн И-баримтын нийт 688 гүйлгээ, 672,847.4 мянган төгрөгийн, 170-аад аж ахуйн нэгж, хувь хүмүүсээс авсан худалдан авалтыг тулган шалгахад урьд онд тооцогдсон худалдан авалтын 36,334.4 мянган төгрөг, 2021 онд шивэгдсэн 12,342.5 мянган төгрөгийн гүйлгээний зөрүү үүссэн байна.	12,342.5	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Эрдэнэбат Нарангарав
ДҮН		13,865.5			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 127/АД/60058

Улаанбаатар хот

СЯГ-2021/41/СТД-ТШЗ
Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны хуулийн дагуу тайлант хугацаанд цахим хуудаст нийт 156 мэдээлэл оруулахаас 19 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, ... жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 6.4.1-д "тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт", гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж мэдээллийг ил тод, хуулийн хугацаанд бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн захирал Б.Батцэнгэл, ерөнхий нягтлан бодогч Э.Нарангарав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
ЮНИСТАР АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

М.ЭНХЖАРГАЛ
Ч.БАТМӨНГӨН

[illegible]